



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 35 (560)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- *Засгийн газрын бүтцийн тухай*
- *Засгийн газрын бүрэлдэхүүний тухай*

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- *Монгол Улсын Засгийн газрын гишүүдийг томилох тухай*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- *"Англи хэлний боловсролын үндэсний хөтөлбөр" батлах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2008 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ
Долоо хоног тутмын

Улаанбаатар хот

2008 оны есдүгээр сарын 21

№35 (560)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

| | | |
|------|---|------|
| 611. | Засгийн газрын бүтцийн тухай | 1009 |
| 612. | Засгийн газрын бүрэлдэхүүний тухай | 1010 |
| 613. | Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 1010 |

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

| | | | |
|------|--|-----------|------|
| 614. | Монгол Улсын Их Хурлын дэд хорооны бүрэлдэхүүний тухай | Дугаар 13 | 1012 |
| 615. | Монгол Улсын Их Хурлын гишүүдийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай | Дугаар 14 | 1013 |
| 616. | Байнгын хорооны гишүүнээр батлах тухай | Дугаар 15 | 1013 |
| 617. | Монгол Улсын Засгийн газрын гишүүдийг томилох тухай | Дугаар 16 | 1014 |
| 618. | Засгийн газрын гишүүдийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай | Дугаар 17 | 1014 |
| 619. | Зарим байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай | Дугаар 18 | 1015 |
| 620. | Зарим дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай | Дугаар 19 | 1016 |

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

| | | | |
|------|---|------------|------|
| 621. | Элчин сайдыг томилох тухай | Дугаар 275 | 1016 |
| 622. | Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай | Дугаар 276 | 1016 |

Дөрөв. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

| | | | |
|------|---|------------|------|
| 623. | "Англи хэлний боловсролын үндэсний хөтөлбөр" батлах тухай | Дугаар 293 | 1017 |
|------|---|------------|------|

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр

Улаанбаатар хот

ЗАСГИЙН ГАЗРЫН БҮТЦИЙН ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газрын бүтцэд дор дурдсан яам ажиллана:

Ерөнхий чиг үүргийн:

1/ Гадаад харилцааны яам;

2/ Сангийн яам;

3/ Хууль зүй, дотоод хэргийн яам;

Чиглэлийн:

4/ Байгаль орчин, аялал жуулчлалын яам;

5/ Батлан хамгаалах яам;

6/ Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам;

7/ Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яам;

ям;

8/ Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам;

9/ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам;

10/ Эрдэс баялаг, эрчим хүчний яам;

11/ Эрүүл мэндийн яам.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2008 оны 9 дүгээр сарын 17-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН

ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр

Улаанбаатар хот

ЗАСГИЙН ГАЗРЫН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүнийг дор дурдсанаар тогтоосугай:

- 1/ Монгол Улсын Ерөнхий сайд;
- 2/ Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын Тэргүүн Шадар сайд;
- 3/ Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын Шадар сайд;
- 4/ Монгол Улсын Засгийн газрын гишүүн - Гадаад харилцааны сайд;
- 5/ Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Сангийн сайд;
- 6/ Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Хууль зүй, дотоод хэргийн сайд;
- 7/ Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Байгаль орчин, аялал жуулчлалын сайд;
- 8/ Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Батлан хамгаалахын сайд;

9/ Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд;

10/ Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд;

11/ Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд;

12/ Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд;

13/ Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Эрдэс баялаг, эрчим хүчний сайд;

14/ Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Эрүүл мэндийн сайд;

15/ Монгол Улсын Засгийн газрын гишүүн - Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2008 оны 9 дүгээр сарын 17-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт " шуудангийн үйлчилгээ." гэж, мөн зүйлийн 5 дахь хэсгийн 2 дахь заалтад " гадаад худалдааны бодлого зохицуулалт; -экспорт, импортын асуудал; -гадаадын хөрөнгө оруулалтын бодлого, зохицуулалт; -эдийн засгийн хамтын ажиллагааны нэгдсэн бодлого, зохицуулалт." гэж, мөн хэсгийн 3 дахь заалтад " гадаадын хөрөнгө оруулалтын бүртгэл." гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн дараахь хэсэг, заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 18 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

"3. Засгийн газрын бүтцэд дор дурдсан яам ажиллана:

Ерөнхий чиг үүргийн

- 1/ Гадаад харилцааны яам;
- 2/ Сангийн яам;
- 3/ Хууль зүй, дотоод хэргийн яам.

Чиглэлийн

- 4/ Байгаль орчин, аялал жуулчлалын яам;
- 5/ Батлан хамгаалах яам;
- 6/ Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам;
- 7/ Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яам;
- 8/ Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам;
- 9/ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам;
- 10/ Эрдэс баялаг, эрчим хүчний яам;
- 11/ Эрүүл мэндийн яам."

2/ 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 1 дэх заалт:

"1/ Монгол Улсын Тэргүүн Шадар сайд:

- оюуны өмч, патент, зохиогчийн эрхийн асуудал;
- стандартчилал, хэмжил зүйн асуудал;
- шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах асуудал;
- чөлөөт бүсийн асуудал;
- үйлдвэржүүлэлтийн бодлого.

2/ Монгол Улсын Шадар сайд:

- бүс нутгийн хөгжлийн нэгдсэн бодлого;
- тодорхой салбарын мэргэжлийн хяналтын асуудал;
- хүүхэд, залуучуудын хөгжлийн асуудал;
- гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх асуудал;
- хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаатай холбоотой шуурхай асуудал."

3/ 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 5, 6, 12, 13 дахь заалт:

"5/ Монгол Улсын Байгаль орчин, аялал жуулчлалын сайд:

- байгаль орчныг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх болон экологийн бодлого;
- цөлжилттэй тэмцэх болон ойжуулалтын асуудал;
- усны нөөцийг нэмэгдүүлэх, ашиглалтыг сайжруулах асуудал;
- ургамал, ан амьтны нөөцийг хамгаалах асуудал, мэдээллийн сан;
- байгаль орчны шинжилгээ, ус, цаг уур болон байгалийн болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх, экологийн аюулгүй байдлыг хангах асуудал, биоаюулгүй байдлын бодлогын асуудал;
- аялал жуулчлалын бодлого.

6/ Монгол Улсын Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд:

- тээврийн тогтолцоог хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэх, уялдааг сайжруулах асуудал;
- төмөр замын тээврийн асуудал;
- иргэний нисэхийн асуудал;
- авто тээврийн асуудал;
- авто замын асуудал;
- далай ашиглах болон усан замын тээврийн асуудал;
- барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн бодлого;

- хот байгуулалт, архитектурын асуудал;
- орон сууцны бодлогын асуудал;
- нийтийн аж ахуйн асуудал;
- газар зохион байгуулалтын бодлого, геодези, зураг зүйн асуудал;
- үл хөдлөх эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн асуудал.

12/Монгол Улсын Эрдэс баялаг, эрчим хүчний сайд:

- геологи, эрдэс баялгийн бодлого;
- газрын тосны талаархи бодлого;
- эрчим хүчний нэгдсэн бодлого;
- түлш, эрчим хүчний үйлдвэрлэлт, дамжуулалт, түгээлтийн асуудал;
- сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх асуудал;
- бүс нутгийн түлш, эрчим хүчний асуудал;
- эрчим хүчний шинэ эх үүсвэрийг бий болгох, ашиглах бодлого;
- хүнд үйлдвэрлэлийн бодлогын асуудал.

13/ Монгол Улсын Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд:

- хөнгөн үйлдвэрлэлийн бодлогын асуудал;
- дотоод худалдааны бодлого зохицуулалт;
- хүн амын хүнсний хангамжийн бодлого;
- хүнсний аюулгүй байдлын асуудал;
- мал аж ахуй болон газар тариаланг эрчимжүүлэн хөгжүүлэх бодлого;
- мал эмнэлэг, малын үржлийн талаар төрөөс явуулах бодлого;
- мал, амьтан, ургамлын хорио цээрийн асуудал;
- бэлчээрийн болон таримал ургамлыг хамгаалах асуудал;
- мал, таримал ургамлын гаралтай хүнсний зүйл, түүхий эдийн экспорт, импортын асуудал;
- хөдөө аж ахуйн эдэлбэр газрын болон бэлчээр ашиглалтын бодлого;
- малыг цаг агаарын гэнэтийн аюулаас хамгаалах бодлого."

3 дугаар зүйл.Засгийн газрын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийн "Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 9 дүгээр зүйл" гэснийг "Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 14 дүгээр зүйл" гэж, "Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн" гэснийг "Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн" гэж, 17 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Шадар сайд" гэснийг "Тэргүүн Шадар сайд" гэж, 18 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн "Шадар сайдтай зөвшилцөн" гэснийг "Тэргүүн Шадар сайдтай зөвшилцөн" гэж, 18' дугаар зүйлийн 10 дахь хэсгийн "Ерөнхий сайд болон Шадар сайдад" гэснийг

"Ерөнхий сайдад" гэж, 18² дугаар зүйлийн 4 дэх хэсгийн "ажлаа хариуцаж, Шадар сайдад ажлаа танилцуулна" гэснийг "ажлаа хариуцна" гэж, 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 2 дахь заалтын "Монгол Улсын Гадаад хэргийн сайд" гэснийг "Монгол Улсын Гадаад харилцааны сайд" гэж, мөн зүйлийн 6 дахь хэсгийн "Шадар сайдын" гэснийг "Тэргүүн Шадар сайд, Шадар сайдын" гэж, 21 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн "Шадар сайд" гэснийг "Тэргүүн Шадар сайд" гэж, 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтын "14 хоногийн дотор" гэснийг "7 хоногийн дотор" гэж, 24 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн "Засгийн газрын" гэснийг "Ерөнхий сайдын" гэж, "29 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтын "Шадар сайдтай санал нэгдэж" гэснийг "дангаар" гэж, мөн зүйлийн 2 дахь хэсгийн 7 дахь заалтын "Ерөнхий сайд болон Шадар сайдад" гэснийг "Ерөнхий сайдад" гэж, 34¹ дүгээр зүйлийн гарчиг болон 1, 2 дахь хэсгийн "Шадар сайдын" гэснийг "Тэргүүн Шадар сайд, Шадар сайдын", мөн зүйлийн 1 дэх хэсгийн "Шадар сайд" гэснийг "Тэргүүн Шадар сайд, Шадар сайд" гэж, 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 2-8 дахь заалтын дугаарыг

"3-9", 12-15 дахь заалтын дугаарыг "11-14" гэж, 18² дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 15-д" гэснийг "20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 14-г" гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн "Шадар сайдтай тохиролцон" гэснийг, 23 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "Шадар сайд болон" гэснийг, 29 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалтын "Шадар сайд, эсхүл" гэснийг тус тус хассугай.

5 дугаар зүйл. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 9, 11 дэх заалтыг тус тус хүчингүй болсонд тооцугай.

6 дугаар зүйл. Энэ хуулийг 2008 оны 9 дүгээр сарын 17-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА** **Д.ДЭМБЭРЭЛ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2008 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр

Дугаар 13

Улаанбаатар хот

Монгол Улсын Их Хурлын дэд хорооны бүрэлдэхүүний тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.3 дахь заалт, 24 дүгээр зүйл, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын дэд хороодыг дараахь бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

1/ Ёс зүйн дэд хороо:

1. Сундуйн Батболд
2. Гарьдхүүгийн Баярсайхан
3. Сангажавын Баярцогт
4. Ламжавын Гүндалай
5. Самбуугийн Ламбаа
6. Данзангийн Лүндэжжанцан
7. Цэндийн Нямдорж
8. Давгадоржийн Очирбат
9. Жамъянхорлоогийн Сүхбаатар
10. Нямаагийн Энхболд

2/ Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийн дэд хороо:

1. Зоригийн Алтай
2. Догсомжавын Балдан-Очир
3. Гаваагийн Батхүү

4. Рэнцэнгийн Буйд
5. Сандагийн Бямбацогт
6. Даваажавын Ганхуяг
7. Дорждамбын Дамба-Очир
8. Цэдэвийн Дашдорж
9. Дашзэвэгийн Зоригт
10. Алмаликийн Тлейхан

3/ Мянганы хөгжлийн зорилтууд болон ядуурлыг бууруулах асуудлын дэд хороо:

1. Дашжамцын Арвин
2. Хоохорын Бадамсүрэн
3. Халтмаагийн Баттулга
4. Сандагийн Бямбацогт
5. Цэдэвийн Дашдорж
6. Даваагийн Көкүшюжан Батбаяр
7. Самбуугийн Ламбаа
8. Алмаликийн Тлейхан

4/ Нутгийн удирдлагын дэд хороо:

1. Норовын Алтанхуяг
2. Цогтын Батбаяр
3. Сундуйн Батболд
4. Жамъянсүрэнгийн Батсуурь
5. Эрдэнийн Бат-Үүл
6. Долзонгийн Дондог
7. Дэлэгийн Загджав

8. Дүрээзгийн Одхүү
9. Давгадоржийн Очирбат
10. Чимэдийн Сайханбилэг

2. Халзхүүгийн Наранхүү
3. Цахиагийн Элбэгдорж

5/ Төсвийн зарлагын хяналтын дэд

7/ Хүний эрхийн дэд хороо:

хороо:

1. Хавдисламын Баделхан
2. Цогтын Батбаяр
3. Лувсанвандангийн Болд
4. Лувсанямын Гантөмөр
5. Цэрэнпилийн Даваасүрэн
6. Дашзэвэгийн Зоригт
7. Цэрэнбатын Сэдванчиг
8. Чүлтэмийн Улаан
9. Дамдингийн Хаянхярваа
10. Очирбатын Чулуунбат

1. Халтмаагийн Баттулга
2. Эрдэнийн Бат-Үүл
3. Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ
4. Энэбишийн Мөнх-Очир
5. Чимэдийн Сайханбилэг
6. Жамъянхорлоогийн Сүхбаатар
7. Баттогтохын Чойжилсүрэн
8. Зандаахүүгийн Энхболд
9. Жадамбын Энхбаяр

2. Энэ тогтоолыг 2008 оны 9 дүгээр сарын 12-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

6/ Тусгай хяналтын дэд хороо:

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

1. Энэбишийн Мөнх-Очир

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2008 оны 09 дүгээр сарын 16-ны өдөр

Дугаар 14

Улаанбаатар хот

Монгол Улсын Их Хурлын гишүүдийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 7 дугаар тойрогт 2008 оны 6 дугаар сарын 29-ний өдөр явуулсан ээлжит сонгуулийн дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

сонгогдсон Пүрэвийн Алтангэрэл, Доржийн Одбаяр, Цэндийн Шинэбаяр нарын бүрэн эрхийг хүлээн зөвшөөрсүгэй.

Монгол Улсын Их Хурлын гишүүнээр

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2008 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр

Дугаар 15

Улаанбаатар хот

Байнгын хорооны гишүүнээр батлах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7 дахь заалт, 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Хурлын гишүүн Доржийн Одбаярыг Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны болон Хууль зүйн байнгын хорооны гишүүнээр тус тус баталсугай.

1. Улсын Их Хурлын гишүүн Пүрэвийн Алтангэрэл, Цэндийн Шинэбаяр нарыг Аюулгүй байдал, гадаад бодлогын болон Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны, Улсын Их

2. Энэ тогтоолыг 2008 оны 9 дүгээр сарын 17-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2008 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр

Дугаар 16

Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн газрын гишүүдийг томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.6 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.7 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэг, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хууль, санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Засгийн газрын гишүүн, сайдаар дор дурдсан хүмүүсийг томилсугай:

1/Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайдаар Норовын Алтанхуягийг;

2/Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын Шадар сайдаар Миезгомбын Энхболдыг;

3/Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Гадаад харилцааны сайдаар Сүхбаатарын Батболдыг;

4/Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Сангийн сайдаар Сангажавын Баярцогтыг;

5/Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайдаар Цэндийн Нямдоржийг;

6/Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдаар Лүймэдийн Гансүхийг ;

7/Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайдаар Лувсанвандангийн Болдыг;

8/Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдаар Ендонгийн Отгонбаярыг;

9/Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдаар Халтмаагийн Баттулгыг;

10/Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдаар Төгсжаргалын Гандийг;

11/Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдаар Түнжингийн Бадамжунайг;

12/Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Эрдэс баялаг, эрчим хүчний сайдаар Дашдоржийн Зоригтыг;

13/Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Эрүүл мэндийн сайдаар Самбуугийн Ламбаг;

14/Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд-Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргаар Бадраагийн Долгорыг.

2.Энэ тогтоолыг 2008 оны 9 дүгээр сарын 19-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**
ДДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2008 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр

Дугаар 17

Улаанбаатар хот

Засгийн газрын гишүүдийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Дор дурдсан хүмүүсийг Засгийн газрын гишүүн, сайдын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй:

1/Миезгомбын Энхболдыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын Шадар сайдын;

2/Ганхуягийн Шийлэгдамбыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Байгаль орчны сайдын;

3/Цэрэндашийн Цолмонг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Барилга, хот байгуулалтын сайдын;

4/Жамъяндоржийн Батхуягийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайдын;

5/Нордовын Болормааг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын;

6/Санжаасүрэнгийн Оюуныг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Гадаад хэргийн сайдын;

7/Раднаабазарын Рашийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Зам тээвэр, аялал жуулчлалын сайдын;

8/Дамдины Дэмбэрэлийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын;

9/Чүлтэмийн Улааныг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Сангийн сайдын;

10/Чимэдийн Хүрэлбаатарыг

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Түлш, эрчим хүчний сайдын;

11/Халзхүүгийн Наранхүүг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Үйлдвэр, худалдааны сайдын;

12/Цэндийн Мөнх-Оргилыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайдын;

13/Цэрэндоржийн Ганхуягийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуйн сайдын;

14/Бямбаагийн Батсэрээдэнийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Эрүүл мэндийн сайдын;

15/Нямаагийн Энхболдыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын Сайд-Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын.

2. Энэ тогтоолыг 2008 оны 9 дүгээр сарын 19-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА** **Д.ДЭМБЭРЭЛ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2008 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр

Дугаар 18

Улаанбаатар хот

Зарим байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7 дахь заалт, 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэг, Улсын Их Хурал дахь МАХН-ын бүлэг, Ардчилсан намын бүлгийн саналыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Улсын Их Хурлын гишүүн Лүймэдийн Гансүхийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны, Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатарын Батболдыг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны, Улсын Их Хурлын гишүүн Миееггомбын Энхболд, Халтмаагийн Баттулга нарыг Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны, Улсын Их Хурлын гишүүн Самбуугийн Ламбаа, Цэндийн Нямдорж нарыг Төрийн байгуулалтын байнгын

хорооны, Улсын Их Хурлын гишүүн Норовын Алтанхуяг, Лувсанвандангийн Болд нарыг Төсвийн байнгын хорооны, Улсын Их Хурлын гишүүн Сангажавын Баярцогтыг Хууль зүйн болон Төрийн байгуулалтын байнгын хорооны бүрэлдэхүүнээс тус тус чөлөөлсүгэй.

2.Улсын Их Хурлын гишүүн Сангажавын Баярцогтыг Төсвийн байнгын хорооны гишүүнээр баталсугай.

3.Энэ тогтоолыг 2008 оны 9 дүгээр сарын 19-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА** **Д.ДЭМБЭРЭЛ**



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2008 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр

Дугаар 19

Улаанбаатар хот

Зарим дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.8 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

зүйн дэд хорооны, Улсын Их Хурлын гишүүн Лувсанвандангийн Болдыг Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнээс тус тус чөлөөлсүгэй.

1. Улсын Их Хурлын гишүүн Халтмаагийн Баттулгыг Мянганы хөгжлийн зорилтууд болон ядуурлыг бууруулах асуудлын дэд хорооны, Улсын Их Хурлын гишүүн Сангажавын Баярцогт, Самбуугийн Ламбаа, Цэндийн Нямдорж нарыг Эс

2. Энэ тогтоолыг 2008 оны 9 дүгээр сарын 19-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 09 дүгээр сарын 18-ны өдөр

Дугаар 275

Улаанбаатар хот

Элчин сайдыг томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ нь:

суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Лувсандоогийн Дашпүрэвийг тохоон томилсугай.

Монгол Улсаас Тайландын Вант Улсад

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 09 дүгээр сарын 18-ны өдөр

Дугаар 276

Улаанбаатар хот

Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Содовын Ононг эгүүлэн татсугай.

2. Монгол Улсаас Нидерландын Вант Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Авирмэдийн Баттөрийг томилсугай.

1. Монгол Улсаас Нидерландын Вант Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 07 дугаар сарын 16-ны өдөр

Дугаар 293

Улаанбаатар хот

"Англи хэлний боловсролын үндэсний хөтөлбөр" батлах тухай

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Англи хэлний боловсролын үндэсний хөтөлбөр"-ийг 1 дүгээр хавсралт, "Англи хэлний боловсролын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-г 2 дугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын төсөвт тусгах болон хандивлагчдын эзэл, тусламж, хөрөнгө оруулагчдын дэмжлэг авах замаар

санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Н.Болормаа, Сангийн сайд Ч.Улаан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Хөтөлбөрийг бусад төсөл, хөтөлбөртэй уялдуулан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Н.Болормаад даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАЯР

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД**

Н.БОЛОРМАА

Засгийн газрын 2008 оны 293 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

АНГЛИ ХЭЛНИЙ БОЛОВСРОЛЫН ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

Дэлхийн интернет мэдээллийн 70 орчим хувь болон дэлхийн шилдэг 500 гаруй их, дээд сургууль англи хэлээр үйл ажиллагаа явуулж, гэрээ, хэлэлцээрийн дийлэнх нь англи хэл дээр хийгдэн улс хоорондын болон олон улсын түвшинд англи хэлний гүйцэтгэх үүрэг, хэрэглээ эрс өсч байна.

Монгол Улсад англи хэлний боловсролын хурдацтай хөгжил нь англи хэлний боловсрол олгох үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, англи хэлний боловсролын стандарт, хөтөлбөр, сурах бичиг, сургалтын орчинг сайжруулах, багшлах боловсон хүчин бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх ажлыг олон улсын жишигт нийцүүлэх, англи хэлний боловсролыг дээшлүүлэхэд байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зэргээр англи хэлийг мэдээлэл харилцаа, ажил хэргийн гол хэрэгсэл болгон хөгжүүлэх зайлшгүй шаардлагыг үндэслэн энэхүү хөтөлбөрийг боловсруулсан болно.

Хоёр. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим

1. хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг Монгол Улсын боловсролын салбарын хөгжлийн бодлого, холбогдох хууль тогтоомж, бусад төсөл, хөтөлбөртэй уялдуулах;
- 2.2. англи хэлний мэдлэг нь мэдээлэл, боловсрол эзэмших харилцааны гол хэрэгсэл байх шаардлагыг үндэс болгох;
- 2.3. хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг хүн амын боловсролын түвшин, эрэлт хэрэгцээ, сонирхол, боломжид тулгуурлан идэвхжүүлэн чанаржуулах;
- 2.4. хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь нээлттэй, хүртээмжтэй, уян хатан, чанартай байх, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, иргэд, сонирхогч талын эрэлт хэрэгцээ, оролцоог хангасан байх;
- 2.5. олон улсын жишигт хүрч, үндэсний онцлогт нийцсэн байх.

Гурав. Хөтөлбөрийн зорилго, зорилт

оруулагчдын дэмжлэг туслалцаатай бүрдүүлж, зүй зохистой ашиглах механизм бий болгох;

Англи хэлний боловсролын үндэсний хөтөлбөрийн зорилго нь англи хэлний боловсрол эзэмших таатай нөхцөлийг бүрдүүлэх, англи хэлийг мэдээлэл, харилцаа, ажил хэргийн гол хэрэгсэл болгон хөгжүүлэхэд оршино.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд дараахь зорилтыг тавьж байна:

3.1. Англи хэлний боловсролыг хөгжүүлэх зорилгоор удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, англи хэлний боловсролын стандарт, сургалтын хөтөлбөрийг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулж мөрдүүлэх. Хөтөлбөрийн энэхүү 1 дэх зорилтын хүрээнд дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

3.1.1. англи хэлний боловсролын өнөөгийн байдалд олон улсын мэргэжлийн байгууллагын дэмжлэгтэйгээр судалгаа, шинжилгээ хийж үнэлэлт, дүгнэлт гаргах;

3.1.2. англи хэлний боловсрол хөгжүүлэх асуудал хариуцсан мэргэшсэн байгууллага бий болгох асуудлыг судалж, шийдвэрлэн англи хэлний сургалт, судалгаа, шинжилгээний ажлын түвшинг олон улсын жишигт хүргэн өргөжүүлэх;

3.1.3. олон улсын жишигт нийцсэн англи хэлний сургалтын стандарт, хөтөлбөр болон сургалтын үр дүнд хийх хяналт, шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийг гадаад орны мэргэжлийн байгууллагатай хамтран боловсруулж, үе шаттайгаар хэрэгжүүлэх.

3.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн тогтвортой эх үүсвэр бий болгох, сургалтын таатай орчинг бүрдүүлэх, багшлах боловсон хүчин, хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх. Хөтөлбөрийн энэхүү 2 дахь зорилтын хүрээнд дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

3.2.1. хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг улсын төсвийн хөрөнгө, хандивлагч орны эзэл, тусламж, хөрөнгө

3.2.2. англи хэлний боловсролын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон улсын байгууллага, сонирхогч талтай холбоо тогтоон өргөжүүлж, хамтарсан арга хэмжээг зохион байгуулж хэрэгжүүлэх;

3.2.3. англи хэлний сургалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг гадаад орны нэр хүндтэй их, дээд, дунд сургууль, олон улсын байгууллагын салбар, төвийг Монгол Улсад байгуулах асуудалд бүх талын дэмжлэг үзүүлж, англи хэлний сургалт, судалгаа, эрдэм шинжилгээний ажил, үйлчилгээнд дэвшилтэт арга хэлбэрийг нэвтрүүлэх;

3.2.4. англи хэлний сургалтын орчинг стандартын шаардлагад нийцсэн техник, тоног төхөөрөмж, заах арга зүйн хэрэглэгдэхүүнээр хангах;

3.2.5. англи хэлний онлайн, офлайн, блендэд сургалт явуулах цахим лаборатори байгуулж ашиглах;

3.2.6. англи хэлний сургалтын гарын авлага, материалыг үндэсний онцлогт нийцүүлэн боловсруулж, цахим хэлбэрт шилжүүлж олон нийтийн хэрэглээнд нэвтрүүлэх;

3.2.7. хэвлэл мэдээллийн хэрэгсэл, интернет, гар утас зэрэг мэдээллийн техник, хэрэгслийг ашиглан англи хэлний зайн сургалт явуулах;

3.2.8. иргэд, төрийн албан хаагчдад англи хэлний хэрэглээний боловсрол олгож түүний түвшинд тавигдах шаардлагыг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулж мөрдүүлэх, урамшууллын механизм бий болгох;

3.2.9. англи хэлний багш бэлтгэж, тэдгээрийн мэргэшил, чадавхийг тасралтгүй дээшлүүлэх ажлыг бусад хөтөлбөрүүдтэй уялдуулан зохион байгуулах;

3.2.10. багшлах боловсон хүчний чадавхийг сайжруулж, нөөцийг нэмэгдүүлэх

зорилгоор жил бүр 150-иас доошгүй багшийг олон улсын жишигт нийцсэн англи хэлний багшлах эрхийн сертификаттай болгох ажлыг хэрэгжүүлэх;

3.2.11. иргэдийн англи хэлний мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэхэд зайн болон албан бус сургалтын арга хэлбэрийг өргөнөөр ашиглах;

3.2.12. англи хэлний боловсролын түвшинг тогтоох үнэлгээний санг бий болгох;

3.2.13. үнэлгээний стандартын дагуу англи хэлний сургалтын байгууллагыг аттестатчилах ажлыг зохион байгуулах.

3.3. Англи хэлийг мэдээлэл, харилцаа, ажил хэргийн гол хэрэгсэл болгон хөгжүүлэх арга хэмжээ авах. Хөтөлбөрийн энэхүү 3 дахь зорилтын хүрээнд дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

3.3.1. англи хэл дээр явуулах мэдээллийн хөтөлбөр, цахим сүлжээ, сонин, сэтгүүл зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгслийг өргөжүүлэх;

3.3.2. англи хэлний багш бэлтгэх сургалтын агуулга, хөтөлбөрийг шинэчлэн, мэргэжлийн зарим хичээлийг англи хэлээр явуулах;

3.3.3. гадаад орны мэргэжлийн их, дээд сургуульд мэргэжил дээшлүүлэх, дадлага хийх болон оюутны солилцоог өргөжүүлэх ажлыг зохион байгуулах;

3.3.4. төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагын ажилтнуудын ажил, мэргэжлийн онцлогт тохирсон англи хэлний сургалт зохион байгуулах;

3.3.5. олон улсын гэрээ, хэлэлцээр, Монгол Улсын хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээг тогтоосон эрх зүйн баримт бичиг, олон нийтэд болон гадаадын хөрөнгө оруулагчдад зориулсан мэдээ, судалгаа, эрдэм шинжилгээ, бүтээлийн мэдээллийн санг англи хэл дээр бэлтгэх арга хэмжээ авах.

Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шат, хяналт-шинжилгээ, үнэлгээ

4.1. Энэхүү хөтөлбөрийг 2009-2020 онд 3 үе шаттайгаар хэрэгжүүлнэ:

4.1.1. I үе шат: 2009-2012 онд иргэдэд англи хэлний боловсрол эзэмшүүлэх удирдлага, зохион байгуулалтын орчинг бүрдүүлж, олон улсын жишигт нийцсэн англи хэлний боловсролын стандарт, агуулга, арга зүй, сургалтын технологи, сургалтын орчин, сурах бичиг, хэрэглэгдэхүүн, үнэлгээний арга зүйг нэвтрүүлж, багшлах боловсон хүчнийг бэлтгэх, давтан сурах, мэргэшүүлэх ажлыг өргөжүүлнэ.

4.1.2. II үе шат: 2013-2015 онд англи хэлийг иргэдийн боловсрол эзэмших, мэдээлэл олох харилцаа, ажил хэргийн гол хэрэгсэл, хэрэгцээ болгох тогтолцоог бүрдүүлнэ.

4.1.3. III үе шат: 2016-2020 онд англи хэлний боловсрол эзэмших үйл явцыг өргөжүүлэн чанартай боловсрол, ажил, үйлчилгээ, бүтээгдэхүүнийг бий болгож, англи хэлийг мэдлэг, мэдээлэл хүртэх гол хэрэгсэл болгон хөгжүүлэх бэлтгэлийг бүрэн хангана.

4.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг үндэсний хэмжээнд бусад төсөл, хөтөлбөртэй уялдуулан зохион байгуулах, хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, тайлагнах арга хэмжээг боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага зохион байгуулна.

4.3. Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдлага, зохион байгуулалтаар хангах, хянах үүрэгтэй ажлын хэсгийг байгуулж ажиллуулж болно.

4.4. Хөтөлбөрийг тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг Засаг дарга хариуцна.

4.5. Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь хөтөлбөрийн

хэрэгжилтийн талаар Засгийн газарт жил бүр танилцуулж байна.

Тав. Хөтөлбөрийн санхүүжилт

5.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараахь эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

5.1.1. улс, орон нутгийн төсвийн хөрөнгө;

5.1.2. хандивлагч орон, олон улсын байгууллагын зээл, тусламж, хандив;

5.1.3. төрийн болон төрийн бус байгууллагын санаачилгаар хуримталсан хөрөнгө;

5.1.4. иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын өөрийн хөрөнгө;

5.1.5. бусад эх үүсвэр.

Зургаа. Хөтөлбөрийн үр дүн

6.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараахь үр дүнд хүрнэ:

6.1.1. мэдээлэл авах, мэдлэг, чадвар эзэмших боломж нэмэгдэж, өрсөлдөх чадвар сайжирна;

6.1.2. иргэд англи хэлийг мэдээлэл, харилцааны гол хэрэгсэл болгон ашиглах боломж нэмэгдэнэ;

6.1.3. боловсролын ажил, үйлчилгээний шинэ дэвшилтэт хэлбэр бий болно;

6.1.4. хүний нөөцийн чадавхи дээшилж, боломж нь өргөжинө;

6.1.5. англи хэлний боловсролын олон улсын жишигт нийцсэн стандарт, хөтөлбөр, сурах бичиг, сургалтын орчин бий болно;

6.1.6. англи хэлний багш нарын мэргэжлийн үр чадвар дээшилнэ;

6.1.7. 2020 онд англи хэлний нийт багш нарын 50-иас доошгүй хувь нь олон улсын жишигт нийцсэн англи хэлний багшлах эрхийн сертификаттай болсон байна.

Долоо. Хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлт

7.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг дараахь шалгуур үзүүлэлтээр үнэлнэ:

7.1.1. англи хэлний боловсрол эзэмшүүлэх эрх зүй, санхүү, техник технологи, сургалтын таатай орчин бүрдсэн байдал;

7.1.2. англи хэлний боловсрол чанартай эзэмших олон улсын жишигт нийцсэн боловсролын стандарт, агуулга, арга зүй, хөтөлбөр, сургалтын төлөвлөгөө, технологи нэвтэрч хэрэгжсэн байдал;

7.1.3. англи хэлний боловсрол эзэмшүүлэх боловсролын тогтолцоо тогтворжин чанаржсан байдал;

7.1.4. сургалт, судалгаа, эрдэм шинжилгээ, ажил, үйлчилгээнд англи хэлийг чөлөөтэй ашиглаж чадах боловсон хүчин, багш, сурагч, оюутан, иргэдийн тоо;

7.1.5. англи хэлний боловсрол эзэмшүүлэх үйл ажиллагаа тогтворжиж, явуулсан сургалт, судалгаа, шинжилгээ, гаргасан эрдэм шинжилгээний бүтээлийн тоо, чанарын өсөлт;

7.1.6. англи хэлний боловсрол эзэмшүүлэх, хэрэглээ болгох чиглэлээр бий болсон ажил, үйлчилгээ, бүтээгдэхүүний тоо, чанар, зах зээлийн тогтвортой өсөлт;

7.1.7. хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн оролцооны өсөлт;

7.1.8. хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зарцуулсан төсвийн хөрөнгө оруулалт, зээл, тусламж, хандивын хэмжээ, үр ашиг, бүтээмж.

АНГЛИ ХЭЛНИЙ БОЛОВСРОЛЫН ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

| д/д | Хэрэгжүүлэх үйл ажиллагаа | Хүрэх үр дүн | Үр дүнгийн шалгуур | Хугацаа | Хариуцах байгууллага |
|-----|--|--|---|-----------|---|
| | Нэг. Англи хэлний боловсролыг хөгжүүлэх зорилгоор удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, англи хэлний боловсролын стандарт, сургалтын хөтөлбөрийг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулж мөрдүүлэх | | | | |
| 1 | Англи хэлний боловсролын өнөөгийн байдалд олон улсын мэргэжлийн байгууллагуудын дэмжлэгтэйгээр судалгаа, шинжилгээ хийн үнэлэлт, дүгнэлт гаргах | Өнөөгийн байдалын тухай Бодит мэдээлэлтэй болно | Дараахь шалгуурыг хангасан байна. Мэдээллийн сангийн багтаамж, гарсан санал зөвлөмж | 2009-2010 | БСШУЯ, СЯ, МХХТГ, аймаг, нийслэлийн ЗДТГ, олон улсын мэргэжлийн байгууллага |
| 2 | Англи хэлний боловсрол хөгжүүлэх асуудлыг харьцусан мэргэжсэн байгууллага бий болгох асуудлыг судалж шийдвэрлэн англи хэлний сургалт, судалгаа, шинжилгээний ажлын түвшинг олон улсын жишигт хүргэн өргөжүүлэх | Англи хэлний боловсролын үйлчилгээний хүртээмж сайжирна | Англи хэлний боловсролын чиглэлээр мэргэшсэн байгууллага бий болно | 2009 | БСШУЯ, СЯ, МХХТГ, аймаг, нийслэлийн ЗДТГ, олон улсын мэргэжлийн байгууллага |
| 3 | Олон улсын жишигт нийцсэн англи хэлний сургалтын стандарт, хөтөлбөр болон сургалтын үр дүнд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийг гадаад орны мэргэжлийн байгууллагатай хамтран боловсруулж, үе шаттайгаар хэрэгжүүлэх | Олон улсын жишигт нийцсэн шалгуур үзүүлэлттэй болсон байна | Олон улсын жишигт нийцэхүйц боловсрол эзэмшсэн иргэдийн тоо | 2009-2012 | БСШУЯ, СЯ, ХЗДХЯ, ГХЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ |

| Хобр. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах шаардлагад санхүүгийн тогтвортой эх үүсвэр бий болгох, сургалтын таатай орчин бүрдүүлэх, багшлах боловсон хүчин, хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх | Англи хэлний боловсролыг дэмжихэд чиглэсэн үндэсний зөвлөлдөх механизм бий болж, англи хэлний боловсролыг дэмжихэд чиглэсэн хөрөнгө оруулалтын үр ашиг сайжирна | Дараахь шалгуур хангасан байна: Англи хэлний боловсролыг дэмжихэд боловсролын хөрөнгийн зарцуулсан хөрөнгийн хэмжээ, англи хэл эзэмшсэн иргэдийн тоо | 2009-2020 БСШУЯ, ГХЯ, СЯ, гадаадын хандивлагчид |
|--|--|---|--|
| 4 | Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг улс, орон нутгийн төсвийн хөрөнгө, хандивлагч орны зээл, тусламж, хөрөнгө оруулагчдын дэмжлэг туслацатай бүрдүүлж, зүй зохистой ашиглах механизм бий болгох | Англи хэлний боловсролын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон улсын байгууллага, сонирхогч талтай холбоо тогтоон өргөжүүлж, хамтарсан арга хэмжээг зохион байгуулж хэрэгжүүлэх | 2009-2020 БСШУЯ, ГХЯ, СЯ, МХХТГ, аймаг, нийслэлийн ЗДТГ, боловсролын үйлчилгээ үзүүлдэг байгууллагууд |
| 5 | Англи хэлний боловсролын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон улсын байгууллага, сонирхогч талтай холбоо тогтоон өргөжүүлж, хамтарсан арга хэмжээг зохион байгуулж хэрэгжүүлэх | Гадаад орноос үзүүлэх дэмжлэг туслацгаа, оролцоо, хамтын ажиллагаа нэмэгдсэн байна | 2009-2020 БСШУЯ, ГХЯ, СЯ, МХХТГ, аймаг, нийслэлийн ЗДТГ, боловсролын үйлчилгээ үзүүлдэг байгууллагууд |
| 6 | Англи хэлний сургалт эрхэлдэг гадаад орны нэр хүндтэй их, дээд, дунд сургууль, олон улсын байгууллагуудын салбар, төвийг Монгол Улсад байгуулах асуудалд бүх талын дэмжлэг үзүүлж, англи хэлний сургалт, судалгаа, эрдэм шинжилгээний ажил, үйлчилгээнд, дэвшилтэт арга хэлбэрийг нэвтрүүлэх | Дэлхийн нэр хүндтэй сургууль, олон улсын байгууллагын салбар, төвүүд байгуулагдсан байна. Багш нарын заах арга, үр чадвар дээшилсэн байна | 2009-2020 БСШУЯ, ГХЯ, СЯ, ХЗДХЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ |
| 7 | Англи хэлний сургалтын орчинг стандартын шаардлагад нийцсэн техник, тоног төхөөрөмж, заах арга зүйн хэрэглэгдэхүүнээр хангах | Сургалтын орчин сайжирна | 2009-2012 БСШУЯ, СЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ, ГХЯ мэргэжлийн байгууллага |
| 8 | Англи хэлний онлайн, офлайн, блендэд сургалт явуулах цахим лаборатори байгуулж ашиглах | Англи хэлний сургалт явуулах интернетэд холбогдсон цахим лаборатори бүхий орчин бүрдсэн байна | 2009-2012 БСШУЯ, СЯ, МХХТГ, аймаг, нийслэлийн ЗДТГ, гадаадын хандивлагч байгууллага |

| | | | | | |
|----|--|---|---|-----------|---|
| 9 | Англи хэлний сургалтын гарын авлага, материалыг үндэсний онцлолт ницүүлэн боловсруулж, цахим хэлбэрт шилжүүлж олон нийтийн хэрэглээнд нэвтрүүлэх | CD, DVD, үзүүлэн төрөөх материалаар бүрдсэн сургалтын багцаар хангагдсан байна. Хэрэглэгдэхүүний хүртээмж, чанар сайжирна | Хэрэглэгчдийн тооны өсөлт | 2009-2020 | БСШУЯ, СЯ, ХЗДХЯ, ГХЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ |
| 10 | Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, интернет, гар утас зарэг мэдээллийн техник хэрэгслийг ашиглан англи хэлний зайн сургалт явуулах | Англи хэлний боловсролын үйлчилгээний хүртээмж сайжирна | Суралцагчдын тоо, үйлчилгээ үзүүлж байгаа телевиз, радио, сонин, сэтгүүл, интернетийн байгууллагуудын тоо | 2009-2020 | БСШУЯ, ГХЯ, СЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ |
| 11 | Иргэд, төрийн албан хаагчдад англи хэлний хэрэглээний боловсрол олгож, түвшинд тавигдах шаардлагаг олон улсын жишигт ницүүлэн боловсруулж мөрдүүлэх, урамшууллын механизм бий болгох | Төрийн захиргааны албан хаагчид, үйлчилгээний ажилтнуудын ажлын байранд тавигдах англи хэлний боловсролын шаардлага боловсруулгдсон байна | Шаардлагад нийцсэн англи хэлний боловсролтой иргэд, төрийн албан хаагчдын тоо | 2009 | БСШУЯ, СЯ, ХЗДХЯ, ГХЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ |
| 12 | Англи хэлний багш бэлтгэж, тэдгээрийн мэдлэг, мэргэжил, чадавхийг дээшлүүлэх ажлыг бусад хөтөлбөрүүдтэй уялдуулан зохион байгуулах | Англи хэлний багш нарын хүрээлцээ хангамж, ур чадвар сайжирна | Балшгийн хангамжийн хувь | 2009-2011 | БСШУЯ, СЯ, ХЗДХЯ, ГХЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ |
| 13 | Багшлах боловсон хүчиний чадварийг сайжруулж, нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор жил бүр 150-нас доошгүй балшийг олон улсын жишигт нийцсэн, англи хэлний багшлах эрхийн сертификатай болгох ажлыг хэрэгжүүлэх | Англи хэлний багш нарын 50 хувь нь олон улсын стандартад нийцсэн сертификатай болсон байна | Англи хэлний сургалтын чанар сайжирна | 2009-2020 | БСШУЯ, СЯ, ХЗДХЯ, ГХЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ |
| 14 | Иргэдийн англи хэлний мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэхэд зайны болон албан бус сургалтын арга хэлбэрийг өргөнөөр ашиглах | Ажлын байран дээрээ англи хэлний боловсролоо дээшлүүлэх боломжийг бүрдүүлсэн байна | Англи хэлээр ажил хэргээ явуулах чадвартай боловсон хүчний тооны өсөлт | 2009-2013 | БСШУЯ, СЯ, ХЗДХЯ, ГХЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ |
| 15 | Англи хэлний боловсролын түвшинг тогтоох үнэлгээний савг бий болгох | Суралцагчдын англи хэлний түвшинг нарийвчлан тогтоох үнэлэмж бүхий нэгдсэн сан бүрдэнэ | Үнэлгээний савг бий болсон байх | 2009-2015 | БСШУЯ, СЯ, ХЗДХЯ, ГХЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ |

| | | | | | |
|---|--|---|---|-----------|--|
| 16 | Үндэслэлийн стандартын дагуу англи хэлний сургалтын байгууллагуудыг аттестатчилах анхны зохион байгуулалт | Цэвэртай сургалт явуулдаг байгууллагын тоо өснө | Стандартай шаардлагад нийцсэн сургалт явуулдаг гэрчилгээтэй байгууллагын тооны өсөлт | 2009-2019 | БСШУЯ, СЯ, ХЗДХЯ, ГХЯ, аймга, нийслэлийн ЗДТГ |
| Гурав. Англи хэлний мэдээлэл, харилцаа, амжилт хэргийн гол хэрэгсэл болгон хөгжүүлэх арга хэмжээ авах | | | | | |
| 17 | Англи хэл дээр явуулах мэдээллийн хөтөлбөр, цахим сүлжээ, сонин, сэтгүүл зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгслийг өргөжүүлэх | Мэдээлэл хүртэх боломж нэмэгдэнэ | Мэдээллийн хэрэгслийн тооны өсөлт | 2010-2020 | БСШУЯ, ХЗДХЯ, ГХЯ, СЯ, ИМХТГ, аймга, нийслэлийн ЗДТГ, боловсролын үйлчилгээ үзүүлдэг байгууллагууд |
| 18 | Англи хэлний бэлтгэлт сургалтын агуулга, хөтөлбөрийг шинэчлэн, мэргэжлийн зарим хичээлийг англи хэлээр явуулах | Бэлтгэл боловсон хүчний чанар сайжирсан байна | Англи хэлээр хичээл заах бэлтгэл хөтөлбөр дээр сургалтаа явуулах сургуулиудын тооны өсөлт | 2010-2020 | БСШУЯ, СЯ, ХЗДХЯ, ГХЯ, аймга, нийслэлийн ЗДТГ |
| 19 | Гараад орны мэргэжлийн их, дээд сургуульд мэргэжил дээшлүүлэх, дарлага хийх болон оюутан солилцоог өргөжүүлэх анхны зохион байгуулалт | Олон улсын хэмжээнд өрсөлдөх чадвартай боловсон хүчин бий болно | Англи хэлний ашиглан олон улсын зах зээлд амжилт чадвартай боловсон хүчний тооны өсөлт | 2009-2020 | БСШУЯ, СЯ, ХЗДХЯ, ГХЯ, аймга, нийслэлийн ЗДТГ |
| 20 | Төрийн болон төрийн бус байгууллагын ажилтнуудын амжилт, мэргэжлийн онцлолт тооцоон англи хэлний сургалт зохион байгуулах | Англи хэлээр мэргэжлийн мэдээлэл авах, ашиглах чадвар сайжирна | Англи хэлээр мэдээлэл авч ашиглах чадвартай ажилтнуудын тооны өсөлт | 2017-2020 | БСШУЯ, СЯ, салбарын явцад, боловсролын үйлчилгээ үзүүлдэг байгууллагууд |
| 21 | Олон улсын газра, хэлэлцээр, Монгол Улсын хууль тогтоомж нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээг тогтоосон эрх зүйн баримт бичгүүд, олон нийтэд болон гадаадын хөрөнгө оруулагчдад зориулсан судалгаа, мэдээлэл, эрдэм шинжилгээний бүтээлийн мэдээллийн санг англи хэл дээр бэлтгэх арга хэмжээ авах | Мэдээлэл хүртэх боломж нэмэгдэнэ | Англи хэл дээр мэдээлэл солилцох боломж бүрдсэн байдал, мэдээллийн сангийн нэр төрөл, хэмжээний өсөлт | 2009-2012 | БСШУЯ, ГХЯ, СЯ, ХЗДХЯ, аймга, нийслэлийн ЗДТГ |

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл.

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.

Улаанбаатар-12
Төрийн ордон

☎ 265958
Индекс: 14003

Хэвлэлийн хуудас 2

☎ 329487